

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№01

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл болон 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2023 оны 4-р сарын 28-ны өдрийн 14:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол даатгал” ХК-ийн байрны 3 давхрын хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга Б.Аюуш: “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн эцнээ санал хураалтаар “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” 23/07 тоот тогтоолыг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тус хурлын комиссын дарга Т.Цацрал, “Гендекс” ҮЦК ХХК-ийн М.Амар, Д.Дэлгэрмаа нар, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган, ТУЗ-ийн гишүүн Л.Таня, хувьцаа эзэмшигч Э.Золзаяа, Компанийн Санхүү эрхэлсэн захирал Н.Батбаяр, Хууль эрх зүйн захирал Т.Наранцогт нар оролцож байна. Санал хураах хайрцгийг нээж байж хурлын ирцийг тогтоох болно. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд харуулан лацадсан хавтасыг нээнэ үү.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: “Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, үүнээс 109,330 ширхэг халаасны хувьцаатай буюу саналын эрхтэй 64,023,011 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 3 саналын хуудас гарлаа. Нийт 269 хувьцаа эзэмшигч байгаа. “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Э.Золзаяа 154 ширхэг, А.Санчирмаа 95 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,464 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна. “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №01-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Хурлын ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлын дэгийг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу эхний танилцуулах асуудал бол “Ногдол ашиг хуваарилахгүй” тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 23/06 тоот тогтоолын 2-т заасны дагуу тус тогтоолын шалтгааныг тайлбарлана уу хэмээн Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулганыг урьж байна.

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 23/06 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган: Тус тогтоолын 2-т 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шалтгаан үндэслэлийг тайбарлахыг миний биед үүрэг болгосон. Ногдол ашиг хуваарилахгүй гол шалтгаан бол компанийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, эрсдэлийн төвшинг харгалзан үзэж 2022 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар Төлөөлөн удирдах зөвлөл шийдсэн болно. Тус шийдвэрийг Монголын Хөрөнгийн биржийн сайт дээр байршуулсан мөн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Хурлын дарга Б.Аюуш: Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган танд баярлалаа! Дараагийн танилцуулах асуудал бол Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн Аудитын дүгнэлт юм.

Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн Аудитын дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Хурлын дэгийн дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх эхний асуудал бол Компанийн 2022 оны санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт юм.

ТУЗ-ийн компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Дараагийн хэлэлцэх асуудал бол 2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэх юм.

Тус асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хурлын комиссын дарга Т.Цацрал та бүхэнд танилцуулах болно.

2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Хурлын дэгийн дагуу та бүхэнд хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Б.Аюуш: Та бүхэнд хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Б.Аюуш: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт

63,997,464 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №02-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Аюуш: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдэрүүдийг танилцуулья.

Нэгдүгээр асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.9, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн "Монгол Даатгал" ХК-ийн 2022 оны компанийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар: ТУЗ-ийн 2023 оны төсвийг Хавсралт №01-ээр баталсугай. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг ТУЗ /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

Дээрх 2 тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа! Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга Т.Цацрал, хурлын дарга Б.Аюуш миний биед хандах, компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээх, мэдээлэл авахад нээлттэй юм шүү. Хувьцаа эзэмшигч та бүхэн компанидаа итгэх итгэлээ хадгалж, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье. Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

Хурал 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:18 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:.....Т.Цацрал

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:.....Б.Аюуш